

## ҮЙЛЧИЛГЭЭ

### ОРОН СУУЦАА ХУВЬЧЛАН “ОРОН СУУЦ ӨМЧЛӨХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭ” АВАХ ИРГЭДИЙН БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Төрийн Өмчийн Хороо, Төрийн болон төрийн өмчийн оролцоотой үйлдвэр албан байгууллага, Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам нийгэмлэг”-ийн эзэмшлийн орон сууцуудаас олгосон **“Орон сууц эзэмших эрхийн бичиг”**
2. “Орон сууц хувьчлах товчооноос олгосон анкет бөглөх.  
Анкетанд доорхи зүйлүүд багтсан байгаа.
  - Хорооны засаг даргын тодорхойлолт, тамга
  - Борлуулалтын байцаагчийн тодорхойлолт, гарын үсэг
  - Хэрэглэгчдэд үйлчлэх төв”-ийн даргын гарын үсэг, тамга
3. Иргэний үнэмлэхний хуулбар
4. Тухайн оршин суугаа байрныхаа харъяа дүүргүүдийн “УБЦТС-ийн Хэрэглэгчдэд үйлчлэх төвүүдээс цахилгааны өр төлбөрийн тооцоотой эсэх тодорхойлолт
5. Иргэний үнэмлэхний хуулбар
6. Банкинд мөнгө тушаах:
  - Улаанбаатар банк **2611038936** ОСНААУГазар гэрчилгээний үнэ 12650 төгрөг
  - Худалдаа хөгжлийн банк **452486244** “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГазар орон сууцны шүүлтгийн төлбөр 2500 төгрөг

---

### ТЕХНИКИЙН ТОДРУУЛГА ХҮСЭЖ БУЙ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭД НЬ ДАРААХЬ МАТЕРИАЛЫГ БҮРДҮҮЛНЭ

ОСНААУГазраас техникийн тодруулга хүсэж буй иргэн, хуулийн этгээд нь дараахь материалыг бүрдүүлнэ. Үүнд:

1. Албан бичиг (өргөдөл)
2. Тухайн нутаг дэвсгэрт зориулж гаргасан Засаг даргын “Барилгын байршил тогтоож, газар ашиглуулах эрх олгох” тухай захирамж, шийдвэр
3. Архитектур төлөвлөлтийн даалгавар
4. Ачаалал хэрэглээг тооцсон тоо хэмжээ
5. Эскиз зураг мөн кадастрын зураг